



ХҮН АМЫН АЖИЛ ЭРХЛЭЛТ

ХЭНТИЙ - 2015

АГУУЛГА

❖ Судалгааны зорилго	
❖ Судалгааны агуулга.....	2
НЭГ. ОЙЛГОЛТ ТОДОРХОЙЛОЛТ.....	2
ХОЁР. ОНОЛЫН ХЭСЭГ.....	8
ГУРАВ. СУДАЛГААНЫ ХЭСЭГ.....	11
3.1. Хөдөлмөр эрхлэлт	
3.1.1.Хүн амын насны бүтэц, ажил эрхлэлтийн үндсэн үзүүлэлтүүд.....	11
3.1.2. Эдийн засгийн идэвхтэй хүн ам, ажиллах хүчний оролцоо, ажил эрхлэлт, ажилгүйдлийн түвшин.....	13
3.1.3. Ажиллагчдын тоо, хүйс, насны бүлэг, боловсролын түвшин, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, байгууллагын төрөл, ажил мэргэжлийн ангиллаар.....	19
3.2. Ажилгүйдэл	
3.2.1 Эдийн засгийн идэвхгүй хүн ам, ажилгүйчүүдийн тоо, хүйс, насны бүлэг, боловсролын түвшин, шалтгаан, бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо.....	26
3.3 Бусад: Албан бус сектор дах ажиллагчдын тоо, хүйс, насны бүлэг, эдийн засгийн салбар, ажил мэргэжлийн ангилал, байршлаар, шинэ бий болсон ажлын байр.....	29
ДҮГНЭЛТ.....	34
АШИГЛАСАН МАТЕРИАЛ.....	36

УДИРТГАЛ

Улс орны баялагийг бүрдүүлэгч гол хөдөлгөгч хүч бол хөдөлмөр бөгөөд эдийн засгийн чухал нөлөө бүхий нөөцөд хөдөлмөр тооцогддог билээ.

Хөдөлмөр эрхлэлт нь улс орны эдийн засгийн хөдөлмөрийн зах зээлийн төлөв байдал, эдийн засгийн өсөлт болон хөгжлийн хандлагаас хамаарч байдаг онцлог салбар юм. Хөдөлмөрийн зах зээлийг үр ашигтай ашиглаж хөгжүүлэх нь хөгжлийн бодлогын төлөвлөлтөнд ихээхэн ач холбогдолтой гэж судлаачид үздэг.

Судалгааны ажлын зорилго: Хөдөлмөр эрхлэлтийн талаарх аймгийн мэдээ, мэдээлэл, статистик тоо баримтуудыг ашиглаж, өнөөгийн хөдөлмөр эрхлэлтийн байдал ямар түвшинд байгааг судлахыг энэхүү танилцуулгаар харуулахыг зорилоо.

Судлагдсан байдал: Манай аймгийн хувьд ажиллах хүчин, хөдөлмөр эрхлэлтийн түвшинг тооцохдоо нэгдүгээрт, ажиллах хүчний судалгаагаар, хоёрдугаарт, ҮСХ болон НХХС-ын хамтарсан 2009 оны 06 сарын 19, 16-ний өдрийн 01/68/94 тоот тушаалаар баталсан Хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчний статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлалын дагуу ажил эрхлэлтийг тооцож байна. Манай судалгаанд ажиллах хүчний судалгаа болон хөдөлмөрийн хэлтсийн захиргааны статистик мэдээллийн тоо баримтуудыг ашиглаж байна.

НЭГ. ОЙЛГОЛТ ТОДОРХОЙЛОЛТУУД

Нийтлэг зүйл

Монгол Улсад “Ажиллах хүчний судалгаа”(АХС)-г 2002-2003 онд анх удаа олон улсын нийтлэг жишиг аргачлалын дагуу улирлаар явуулсан нь хөдөлмөрийн зах зээл дэх улирлын хэлбэлзлийг тусгасан хүн амын хөдөлмөр эрхлэлтийн үндэсний хэмжээний суурь судалгаа болсон билээ. Харин олон улсын нийтлэг аргачлалын дагуу ажиллах хүчний судалгааг улирлаар тогтмол явуулж байх нь зүйтэй гэж үзэн 2004 онд Монгол улсын “Статистикийн тухай” хуулинд нэмэлт заалт оруулсны дагуу 2006 оноос эхлэн ажиллах хүчний судалгааг тогтмол явуулж, үр дүнг улирлаар нэгтгэн тархааж байгаа билээ. Энэ хугацаанд ажиллах хүчний судалгаатай хавсарга болгон Хүүхдийн хөдөлмөрийн судалгааг гурван удаа, Хувиараа хөдөлмөр эрхлэлтийн судалгааг нэг удаа явуулж, судалгааны үр дүнгийн тайланг тусад нь боловсруулан гаргаж тархаасан. АХС нь олон улсын нийтлэг тодорхойлолт, арга зүйг ашиглан хүн амын эдийн засгийн идэвхийг сүүлийн 7 хоногийн буюу тухайн үеийн, сүүлийн 12 сарын буюу байнгын идэвхийн аргачлалаар тооцох замаар хүн амын ажил эрхлэлтийн байдлыг тодорхойлон, хүн амын ажил эрхлэлт, ажилгүйдлийн холбогдолтой статистик үзүүлэлтүүдийг бүс нутаг, хот, хөдөө, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, ажил мэргэжлийн ангилал, ажил эрхлэлтийн статусаар улирлын нөлөөллийг тусган тооцож гаргаснаараа чухал ач холбогдол бүхий судалгаа юм.

Ажилгүйдэл, бүрэн бус хөдөлмөр эрхлэлт байсаар байгаа өнөөгийн нөхцөлд хөдөлмөр эрхлэлтийн стратеги, хөтөлбөрийг боловсруулах, үр дүнг дүгнэхэд шаардлагатай хөдөлмөр эрхлэлтийн талаарх статистикийн суурь мэдээллийг өргөжүүлэн баяжуулах, шалгуур үзүүлэлтүүдийг оновчтой зөв тооцон гаргах,

мэдээллийн давтамжийг тогтмолжуулах, хөдөлмөрийн статистикийн системийг боловсронгуй болгох шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Хүн амын хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчний мэдээ, тайлан гаргах, судалгаа явуулах болон холбогдох үндсэн үзүүлэлтүүдийг тооцоход ашиглах ойлголт, тодорхойлолт, тооцох аргачлал Үндэсний Статистикийн хорооны дарга, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд /хуучнаар/-ын 2009 оны 01/68/94 тоот хамтарсан тушаал 6 дугаар сард шинэчлэн батлагдсантай холбогдуулан 2009 оны 3 дугаар улирлаас эхлэн уг аргачлалын дагуу АХС-ны асуулга, зааврыг шинэчлэн батлагдсан ойлголт, тодорхойлолтын дагуу холбогдох өөрчлөлтүүдийг тусган боловсруулсан.

Монгол Улсад албан бус сектор дахь хөдөлмөр эрхлэлт нь орлогын эх үүсвэр бүрдүүлэлтийн нэлээд хэсгийг хангадаг. Иймд Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага (ОУХБ)-аас зөвлөмж болгосноор албан бус секторын талаарх тоо мэдээг статистикийн тогтолцооны нэг хэсэг болгож тогтмол цуглуулснаар албан бус секторын цар хүрээ, хэмжээ, төлөв байдлын талаар байнгын мэдээлэлтэй болж, гарч буй өөрчлөлтөнд хяналт тавих боломжтой болж байгаа юм.

Судалгааны зорилго

Хөдөлмөрийн статистикийн суурь мэдээллийг өргөжүүлэн баяжуулж, хөдөлмөр эрхлэлтийн хэв шинжийг бүрэн хамруулсан дүн шинжилгээ хийх, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажилгүйдэл, ядуурлыг бууруулахад чиглэгдсэн Засгийн газрын бодлого, хөтөлбөр боловсруулах, тэдгээрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ хийх, үнэлэлт дүгнэлт өгөх, хөдөлмөрийн зах зээлийг зөв төлөвшүүлэн хөгжүүлэхэд нь бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагчид, бизнес эрхлэгчид, шинжлэн судлаачид, төр захиргааны албаны ажилтан хэн бүхэнд гарын авлага, тогтмол мэдээллийн эх сурвалжийг бий болгоход оршино.

Хамрах хүрээ

Ажиллах хүчний судалгаагаар хүн амын хөдөлмөр эрхлэлтийн талаарх бодит тоон мэдээллийг улсын хэмжээнд болон бүс нутаг, аймгийн түвшинд тооцож, тодорхойлно. Үүний тулд судалгааг байршлын хувьд Монгол улсыг бүхэлд нь хамруулан өргөн цар хүрээтэй явуулан улсын хэмжээнд 4 бүс нутаг, Улаанбаатар хотын нийт 12816 өрхийн 15, ба түүнээс дээш насны гишүүдээс асуулга авдаг ба Хэнтий аймгийн хувьд жилд 432 өрх хамрагдсан ба хамралтын түвшин 100.0 хувьтай байна.

Мэдээлэл цуглуулалт

Энэ удаагийн судалгааны асуулга нь 8 бүлэг, 142 асуултаас бүрдэж байгаа нь өмнөх судалгааны зорилготой холбоотой бөгөөд хүүхдийн хөдөлмөр эрхлэлттэй холбогдолтой нарийвчилсан үзүүлэлтүүдийг хассантай холбоотой.

Судалгааны тоологч, ахлагч нар нь сонгогдсон өрхөд очиж 15, ба түүнээс дээш насны гишүүн бүртэй нэг бүрчлэн уулзаж, ярилцлага хийх замаар мэдээллээ цуглуулсан.

Мэдээлэл боловсруулалт

Өрхөөс ярилцлага авч, цуглуулсан мэдээллийг зааврын дагуу шалгаж, кодлон компьютерт програмд шивэн оруулах, шалгах, засвар хийсний дараа төвд дамжуулах ажлыг аймгийн хэмжээнд статистикийн хэлтсийн ажиллах хүчний судалгаа хариуцсан ахлагч, мэргэжилтэн нар хийж гүйцэтгэсэн.

АХС–ны мэдээллийг компьютерт шивж оруулах, шалгах, засварлахад тооллого, судалгааны мэдээлэл боловсруулдаг CSPro 4.0 багц програмыг, бэлэн болсон мэдээллийн үр дүнг боловсруулж, холбогдох хүснэгтүүдийг SPSS13.0 програмыг тус тус ашиглан улмаар статистикийн дүн шинжилгээ хийж, судалгааны боловсруулалтын үр дүнг хянах, илэрсэн алдааг засварласны үндсэн дээр судалгааны үр дүнгийн хүснэгтүүдийг боловсрууллаа.

Ойлголт тодорхойлолтууд:

Өрх

Өрх гэдэг нь байнга хамтран амьдарч, орлогоо нэгтгэн хоол хүнсээ бэлтгэж, нэг тогооноос хоол иддэг нэг буюу хэд хэдэн хүмүүсийг хэлнэ. Эдгээр хүмүүс нь хамаатан садан болон ажил олгогчтойгоо хамтран амьдардаг, цусан төрлийн хамааралгүй, гэрийн үйлчлэгч, бусад хөлсний ажилчид ч байж болно.

Өрхийн тэргүүлэгч

Өрхийн тэргүүлэгч гэдэг нь бусад гишүүд нь өрхийн тэргүүлэгч хэмээн хүлээн зөвшөөрсөн өрхийн гишүүн бөгөөд насанд хүрсэн хүн байна. Хэрвээ тухайн сууцанд нэгээс олон өрх амьдран сууж байвал төдий тооны өрхийн тэргүүн байна.

Эдийн засгийн үйл ажиллагаа

Зах зээлд болон хувийн хэрэглээнд зориулж үйлдвэрлэсэн бараа, үйлчилгээний үйл ажиллагааг хамруулна. Үндэсний тооцооны системийн хүрээнд бараа, үйлчилгээнд худалдах, солилцох, өөрийн аж ахуйд хэрэглэх зорилгоор боловсруулсан түүхий эд материал, зах зээлд нийлүүлж байгаа бүхий л бүтээгдэхүүн, үйлчилгээ, зах зээлд худалдах, өөртөө хэрэглэх зорилгоор өрхөд үйлдвэрлэж байгаа бараа үйлчилгээг хамруулна.

Энэ нь цалин хөлстэй болон цалин хөлсгүй, албан болон албан бус хэлбэртэй байж болно. Жишээлбэл: өөрийн өрхийн аж ахуйн бизнест цалин хөлсгүй оролцож буй хүнийг эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж байна гэж үзнэ.

Эдийн засгийн бус үйл ажиллагаа

Хүүхэд, өндөр настан асрах, гэр цэвэрлэх, хоол унд бэлтгэх зэрэг цалин хөлс, орлого олохгүй үйл ажиллагааг хамруулна. Үүнд:

- Гэр орон цэвэрлэх, хувцас бусад нэхмэл, сүлжмэл эдлэл оёх, арчлах
- Хувцас, угаах, индүүдэх, гэр байшин, эд хогшил сэргээн засварлах
- Хоол унд хийх, аяга таваг угаах
- Хүүхэд асрах
- Өвчтэй хүн, өндөр настнуудыг асрах
- Гэрийнхээ хэрэгцээт зүйлийг худалдан авах, дэлгүүр явах

Ажиллагч

Ажиллагч гэдэг нь цалин хөлс, орлого олох зорилгоор эдийн үасгийн үйл ажиллагаанд оролцож, хөдөлмөр эрхлэлтийн аль нэг хэв шинж (статус)-д хамрагдаж байгаа иргэнийг хэлнэ.

Ажиллагч гэдэг нь ажиллах хүчинд хамаарагдах тухайн хугацаанд ажил, хөдөлмөр эрхэлж байгаа болон тухайн долоо хоногт ажил эрхлээгүй ч ажилтай байсан хүнийг хэлнэ. Тухайн хугацаанд (сүүлийн долоо хоногт) ямар нэг байдлаар ажил хөдөлмөр эрхэлсэн (нэг цагаас дээш хугацаагаар) хүнийг ажилтай гэнэ. Өвчлөл, гэмтэл, амралт, чөлөө, цаг агаарын таагүй байдал, ажил хаялт болон бусад шалтгаанаар түр хугацаагаар ажил эрхлэхгүй байгаа ч ажилтай, бизнес эрхэлдэг бол тухайн хүнийг ажиллагч гэж үзнэ.

Хувиараа хөдөлмөр эрхлэгч

Дангаараа буюу бусадтай хамтран өөрийн багаж, тоног төхөөрөмж, бусад материалыг ашиглан эдийн засгийн үйл ажиллагааг хараат бусаар явуулж, урт хугацаагаар түр ажилтан авч ажиллуулдаггүй (богино хугацаагаар ажилтан ажиллуулж болно), бизнесийнхээ үйл ажиллагаанд нөлөөлөх шийдвэрийг бие даан гаргадаг иргэнийг хэлнэ.

Мөн ажиллагчдын оролцоогүйгээр аж ахуйн нэгж, байгууллага, хамтарсан үйлдвэрийг удирдаж байгаа хүнийг хувиараа хөдөлмөр эрхлэгч гэнэ. Харин өрхийн гишүүд цалин хөлсгүйгээр энд ажиллаж болно.

Өрхийн бизнест цалин хөлсгүй оролцогч

Өрхийн аж ахуйн нэгжид цалин хөлсгүйгээр нэг цагаас доошгүй ажилласан хүн. Ялангуяа хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас агнуурын салбарт өрхийн аж ахуй зонхилж байдаг тул цалин хөлсгүй оролцогч их байдаг. Өрхийн бизнест цалин хөлсгүй оролцсон хүүхдүүдийг хөдөлмөр эрхэлсэн гэж үзнэ.

Ажилгүйчүүд

Ажилгүйчүүд гэдэг нь ажиллах хүчинд хамаарагдах тухайн хугацаанд ажил, хөдөлмөр эрхлээгүй байгаа болон тухайн долоо хоногт ажил эрхлээгүй боловч ажил эрхлэхэд бэлэн байсан, ажил хөдөлмөр идэвхтэй хайсан хүнийг хэлнэ. Ажил хөдөлмөр эрхлэдэггүй ч ажил эрхлэх боломжтой байгаа, ажилд орох өргөдлөө өгсөн болон ярилцлаганд орохоор хүлээж байгаа хүнийг мөн ажилгүйчүүд гэж тодорхойлно.

Эдийн засгийн идэвхтэй хүн ам

НҮБ-ын үндэсний тооцооны системийн хүрээнд, тодорхой цаг хугацаанд тодорхойлогдсон бүтээгдэхүүн, үйлчилгээг үйлдвэрлэхэд ажиллах хүчээ нийлүүлж байгаа ажиллагчид, нийлүүлэхэд бэлэн байгаа ажилгүйчүүдийг эдийн засгийн идэвхтэй хүн амд тооцдог. Эдийн засгийн идэвхтэй хүн амыг урт хугацаагаар хэмжигдэх байнгын идэвхтэй хүн ам, нэг долоо хоног буюу нэг өдрийн хугацаагаар хэмжигдэх тухайн үеийн идэвхтэй хүн ам буюу “Ажиллах хүч” гэсэн хоёр аргаар тодорхойлно.

Байнгын идэвхтэй хүн ам

Заагдсан хязгаараас дээш настай (АХС-гаар 15 ба түүнээс дээш насыг авсан) ажилтай болон ажилгүй байсан нь урт хугацаагаар буюу хуанлийн жилийн (сүүлийн 12 сарын) туршид эрхэлсэн үндсэн үйл ажиллагааныхаа байдлаар тодорхойлогддог хүн амыг хэлнэ.

Тухайн үеийн идэвхтэй хүн ам

Ажиллах хүч буюу тухайн үеийн идэвхтэй хүн амд ажилтай болон ажилгүй байсан нь судалгааны өмнөх сүүлийн 7 хоногт эрхэлсэн үндсэн үйл ажиллагааных нь байдлаар тодорхойлогдож байгаа ажиллагчид болон ажилгүйчүүдийн доторхи тодорхой шаардлагыг хангах бүхий л хүмүүсийг хамруулна.

Эдийн засгийн идэвхгүй хүн ам

Тогтоосон насны хязгаараас дээш насны байнгын болон тухайн үеийн эдийн засгийн идэвхтэй хүн амд хамаарагдахгүй хүн ам болон тогтоосон насны хязгаараас доош насны хүнийг эдийн засгийн идэвхгүй хүн ам гэнэ.

Эдийн засгийн идэвхгүй хүн амд хөдөлмөрийн нөхцөл, онцлогоос шалтгаалан тэтгэвэрийн наснаас өмнө тэтгэвэр, тэтгэмж тогтоолгосон хүн ам, хөдөлмөрийн чадвараа 6 сараас дээш хугацаагаар түр болон бүрэн алдсан иргэн , хөдөлмөрийн насны өдрөөр суралцагч, хүндэтгэх ба хүндэтгэх бус шалтгаанаар хөдөлмөр эрхлээгүй болон хөдөлмөрийн насанд хүрээгүй хүн амыг хамруулна.

Эдийн засгийн идэвхгүй хүн амыг урт хугацаагаар хэмжигдэх байнгын идэвхгүй хүн ам, нэг долоо хоног буюу нэг өдрийн хугацаагаар хэмжигдэх тухайн үеийн идэвхгүй хүн ам гэсэн хоёр аргаар тодорхойлно.

Байнгын идэвхгүй хүн ам

Урт хугацаанд буюу сүүлийн 12 сарын туршид эрхэлсэн үндсэн үйл ажиллагаагаараа эдийн засгийн идэвхтэй хүн амд тооцогдохгүй (ажиллагчид болон ажилгүйчүүдийн алинд ч хамаарахгүй) хүмүүсийг эдийн засгийн байнгын идэвхгүй хүн ам гэнэ. Үүнд: оюутан сурагч, гэрийн ажилчид, тэтгэврийн орлого авдаг хүмүүсийг хамруулна.

Тухайн үеийн идэвхгүй хүн ам

Сүүлийн 7 хоногт сургуульд суралцаж байгаа, гэрийн ажлаа хийж байгаа, тэтгэвэрт гарсан болон өндөр настай, тахир дутуу зэрэг шалтгаанаар тухайн хугацаанд ажиллагчид болон ажилгүйчүүдийн алинд ч хамаарахгүй хүмүүсийг тухайн үеийн эдийн засгийн идэвхгүй хүн ам буюу ажиллах хүчинд хамаарагдахгүй хүн ам гэнэ.

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар

Тухайн хүний ажиллаж байгаа ажлын байр, үйлдвэрийн газар, байгууллагын үйлдвэрлэдэг үндсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний төрлөөр тодорхойлогдоно. Олон Улсын Стандарт Ангилал 4-т нийцүүлэн боловсруулсан “Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал”-ыг ашигласан.

Ажил мэргэжил

Цалин, хөлс, орлого олох зорилгоор тухайн хүний хийж гүйцэтгэж буй эдийн засгийн үйл ажиллагааны ажил, мэргэжлийн төрлийг ажил, мэргэжил гэнэ. Хэрвээ тухайн хүн ажилгүй байгаа бол эрхлэхэд бэлэн байгаа ажил, мэргэжлийн төрлийг тухайн хүний ажил, мэргэжил гэж үзнэ.

Үндсэн ажил

Тухайн хугацаанд (сүүлийн долоо хоног, сүүлийн 12 сард) нэгээс олон ажил цалинтай болон хувиараа эрхэлж байгаа бол нийгмийн болон хууль зүйн тал, цалин хөлсний хэмжээ, ажиллаж байгаа цагаас нь хамааруулан үндсэн ажлыг тодорхойлно. Хэрвээ тухайн хүн зөвхөн нэг л ажил эрхэлдэг бол түүнийг үндсэн ажилд тооцно.

Давхар ажил

Тухайн хугацаанд (сүүлийн долоо хоног, сүүлийн 12 сард) нэгээс олон ажил цалинтай болон хувиараа эрхэлж байгаа бол нийгмийн болон хууль зүйн тал, цалин хөлсний хэмжээ, ажиллаж байгаа цагаас нь хамааруулан үндсэн ажлаас бусад ажлыг давхар ажил гэж тодорхойлно.

Бүрэн бус хөдөлмөр эрхлэлт

Тухайн хугацааны үндсэн үйл ажиллагаандаа ажлын цагийн тогтоосон доод хязгаараас бага цагаар ажилладаг, эсвэл нэмэлт цагаар ажиллах хүсэлтэй бөгөөд ажиллахад бэлэн байгаа, түүнчлэн тухайн хүний эзэмшсэн мэргэжил, ур чадварыг бүрэн ашиглахгүй, бүтээмж доогуур байхыг хамруулна. Бүрэн бус хөдөлмөр эрхлэлт нь ил, далд гэсэн 2 хэлбэртэй байна. Бүрэн бус ажил эрхэлж байгаа хүн нь цалин, хөлстэй болон хувиараа эрхэлж байгаа тухайн үйл ажиллагаанд тогтоогдсон цагаас бага цагаар өөрийн хүслээр бус ажиллаж байгаа тухайн хугацаанд нэмэлт ажил хайж байгаа болон нэмэлт ажил эрхлэхэд бэлэн байгаа хүн юм.

Ажил олгогч

Өөрийн ажил мэргэжлээс үл хамааран нэг болон түүнээс дээш ажиллагчидтай аж ахуйн нэгж, хамтарсан үйлдвэрийг удирдаж байгаа хүнийг ажил олгогч гэнэ. Эдийн засгийн үйл ажиллагаатай холбоотой шийдвэрийг бие даан гаргаж, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээнээс олсон ашиг буюу ашиг олох боломжоос шууд хамааран бизнестээ урт хугацаагаар нэг буюу түүнээс дээш ажилтныг хөдөлмөрийн болон бусад гэрээ, тохиролцооны үндсэн дээр авч ажиллуулж буй эзэн, байгууллагын удирдлагыг хэлнэ.

Цалин хөлс

Мөнгөн болон биет хэлбэрээр авч байгаа хөлс, урамшуулал, гарын мөнгө, ашиг орлогын хувь, илүү цаг ажилласны мөнгө, ажил олгогчоос хангаж байгаа хоол хүнс, байрыг цалин хөлсөд хамааруулна.

ХОЁР. ОНОЛЫН ХЭСЭГ

Судалгааны үзүүлэлтийн ойлголт, тодорхойлолт, тооцсон аргачлал:

Хөдөлмөр эрхлэлттэй холбоотой судалгааны үндсэн үзүүлэлтүүдэд дараах ойлголтуудыг авч үздэг.

- Хөдөлмөрийн насны хүн ам;
- Ажиллах хүч буюу эдийн засгийн идэвхтэй хүн ам;
- Ажил эрхэлдэг хүн ам буюу ажиллагсад;
- Ажилгүйчүүд;
- Эдийн засгийн идэвхгүй хүн ам;
- Эдийн засгийн ачаалал;
- Хөдөлмөр эрхлэлтийн түвшин;
- Ажиллах хүчний оролцооны түвшин;
- Ажилгүйдлийн түвшин;
- Эдийн засгийн идэвхгүй байдлын түвшин;
- Хөдөлмөрийн бүтээмж зэрэг болно.

Тухайлбал:

Хөдөлмөрийн насны хүн ам:

Хөдөлмөрийн насны хүн амд 15-59 насны хоорондох нийт хүн амыг хамруулж үздэг.

Ажиллах хүч буюу эдийн засгийн идэвхтэй хүн ам:

Эдийн засгийн идэвхтэй хүн ам буюу ажиллах хүчинд үндэсний тооцооны системийн хүрээнд, хөдөлмөрийн насанд хүрсэн, ажил хийх чадвартай ажиллах хүчээ нийлүүлж байгаа ажиллагсад болон хөдөлмөрөө нийлүүлэхэд бэлэн байгаа ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй иргэдийг хамруулдаг.

Ажил эрхэлдэг хүн ам буюу ажиллагсад:

Ажиллагчид гэж цалин хөлс, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд оролцож, хөдөлмөр эрхлэлтийн аль нэг хэв шинжид хамрагдаж буй иргэдийг хэлнэ. Аж ахуйн нэгж байгууллагад орон тооны ажиллагчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, хамтран ажил гүйцэтгэгчид, өрхийн аж ахуйд ажиллагсад болон ажил эрхэлдэг боловч тодорхой шалтгаанаар (ээлжийн амралттай, өвчтөй, чөлөөтөй гэх мэт) ажиллаагүй хүн амыг хамааруулна.

Ажилгүйчүүд

Монгол улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстөй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстөй ажил идэвхтэй хайж байгаа хөдөлмөр зохицуулалтын албанд бүртгүүлсэн хүмүүсийг ажилгүйчүүдэд хамруулна.

Эдийн засгийн идэвхгүй хүн ам

Эдийн засгийн идэвхгүй хүн амд эдийн засгийн идэвхтэй хүн амд хамаарагдахгүй хөдөлмөрийн насны нийт хүн ам болон хөдөлмөрийн насанд хүрээгүй, хүн ам, хөдөлмөрийн наснаас дээш насны хүн амыг хамруулна.

Эдийн засгийн ачаалал (ЭЗА)

Эдийн засгийн ачаалал нь (ЭЗА) тухайн улс орны эдийн засгийн ачааллыг харуулдаг гол үзүүлэлт юм. Тухайлбал, эдийн засгийн ачаалал бага байх тусам эдийн засгийн идэвхгүй хүн амын тоо нь эдийн засгийн идэвхтэй хүн амын тооноос төдий чинээ цөөн байгааг харуулж байна.

Тооцох арга зүй: Эдийн засгийн ачаалал нь эдийн засгийн идэвхтэй хүнд ногдох эдийн засгийн идэвхгүй хүн амын эзлэх хувийн жингээр тодорхойлогдоно.

$$\text{ЭЗА} = \frac{\text{Эдийн засгийн идэвхгүй хүн амын тоо}}{\text{Эдийн засгийн идэвхтэй хүн амын тоо}} \times 100\%$$

Ажиллах хүчний идэвхийн ерөнхий коэффициент

Нийт хүн амд хөдөлмөрийн насны хүн амын эзлэх хувь өндөр байвал ажиллах хүчний идэвхийн ерөнхий коэффициент (АХИЕК) нь өндөр гарна. Энэхүү үзүүлэлтэд хүн амын насны бүтэц чухал нөлөө үзүүлдэг бөгөөд нас, хүйсийн бүлгээр тооцож болно.

Тооцох арга зүй: Ажиллах хүчний идэвхийн ерөнхий коэффициент (АХИЕК) нь эдийн засгийн идэвхтэй хүн амын нийт хүн амд эзлэх хувийн жингээр тодорхойлогдоно.

$$\text{АХИЕК} = \frac{\text{Эдийн засгийн идэвхтэй хүн ам}}{\text{Нийт хүн амын тоо}} \times 100\%$$

Хөдөлмөр эрхлэлтийн түвшин:

Хөдөлмөр эрхлэлтийн түвшин нь (ХЭТ) нь эдийн засгийн идэвхтэй хүн амын хэдэн хувийг ажил эрхэлж байгаа хүмүүс бүрдүүлж байгааг харуулдаг.

Тооцох арга зүй: Хөдөлмөр эрхлэлтийн түвшинг тодорхойлохдоо ажиллагчдын тоог эдийн засгийн идэвхтэй хүн амын тоонд харьцуулж тооцно.

$$\text{ХЭТ} = \frac{\text{Ажиллагсдын тоо}}{\text{Эдийн засгийн идэвхтэй хүн ам}} \times 100\%$$

Ажиллах хүчний оролцооны түвшин

Ажиллах хүчний оролцооны түвшин (АХОТ) нь нийт хүн амаас хөдөлмөрийн бус насны хүн ам, тухайлбал эдийн засгийн үйл ажиллагаанд оролцдоггүй хүүхэд болон тэтгэврийн насны хүмүүсийг хасаж тооцдог учраас илүү нарийвчилсан үзүүлэлт юм. Энэ үзүүлэлтэд хүн амын насны бүтэц чухал нөлөө үзүүлдэг ба энэ үзүүлэлтийг ажиллах хүчний идэвхийн тусгай коэффициент (АХИТК) гэж нэрлэдэг. Ажиллах

хүчний оролцооны түвшин өндөр байхын хэрээр хөдөлмөрийн насны хүн амын дунд ажил эрхэлж байгаа, эсвэл ажил идэвхтэй хайж байгаа хүн амын эзлэх хувь өндөр байна гэсэн үг юм. Ажиллах хүчний оролцооны түвшин нь тухайн улс орны хөдөлмөрийн зах зээлийн хөгжил, хүн амын эдийн засгийн идэвхийн байдлыг харуулдаг гол үзүүлэлт бөгөөд хөдөлмөрийн насны (15-59) хүн амын дунд ажиллах хүч буюу хөдөлмөр эрхэлж байгаа болон ажил идэвхтэй эрж, хайж байгаа, ажиллахад бэлэн ажилгүй хүн амын эзлэх хувь юм. Энэхүү үзүүлэлт нь хөдөлмөрийн насны хүн амын хөдөлмөр эрхлэлтийн байдал, эдийн засагт хөдөлмөрийн насны хүн амыг ажлын байраар хангах зорилтын хэрэгжилтийг хянах хэмжүүр болно.

Тооцох арга зүй: Ажиллах хүчний оролцооны түвшин (АХОТ) -г хөдөлмөрийн насны хүн амд эдийн засгийн идэвхтэй хүн амын эзлэх хувиар тодорхойлдог.

$$\text{АХИТК} = \frac{\text{Эдийн засгийн идэвхтэй хүн ам}}{\text{Хөдөлмөрийн насны хүн амын тоо}} \times 100\%$$

Мөн ажиллагчид болон ажилгүйчүүдийн нийлбэр нь эдийн засгийн идэвхтэй хүн ам буюу ажиллах хүчийг бүрдүүлдэг. Энэхүү ажиллах хүчний хөдөлмөрийн насны хүн амын тоонд эзлэх хувийг ажиллах хүчний оролцооны түвшин гэж нэрлэдэг. Үүнийг үзүүлбэл:

$$\text{АХОТ} = \frac{\text{Ажиллагсад} + \text{Ажилгүйчүүд}}{\text{Хөдөлмөрийн насны хүн амын тоо}} \times 100\%$$

Ажилгүйдлийн түвшин

Ажилгүйдлийн түвшин өндөр байна гэдэг нь нийгмийн хуримтлал багасаж, үйлдвэрлэл, эдийн засгийн хөгжил хоцрогдож, ядуурал нэмэгдэж байгааг харуулдаг учраас ажилгүйдлийг бууруулах нь макро эдийн засгийн бодлогын нэг зорилт болдог. Ажилгүйдэл нь улс орны нийгэм, эдийн засагт ихээхэн сөрөг үр дагавартай байдаг.

Тооцох арга зүй: Ажилгүйдлийн түвшинг (АТ) ажилгүй иргэдийн тоог эдийн засгийн идэвхтэй хүн амын тоонд харьцуулж тооцно.

$$\text{АТ} = \frac{\text{Ажилгүй иргэдийн тоо}}{\text{Эдийн засгийн идэвхтэй хүн амын тоо}} \times 100\%$$

Эдийн засгийн идэвхгүй байдлын түвшин(ЭЗИБТ)

Эдийн засгийн идэвхгүй хүн амын тоог хөдөлмөрийн насны хүн амын тоонд харьцуулсан харьцааг эдийн засгийн идэвхгүй байдлын түвшин гэнэ.

$$\text{ЭЗИБТ} = \frac{\text{Эдийн засгийн идэвхтэй хүн амын тоо}}{\text{Хөдөлмөрийн насны хүн амын тоо}} \times 100\%$$

Хөдөлмөрийн бүтээмж

Нэгж хөдөлмөрийн(хөдөлмөр эрхэлж буй хүн ам буюу ажиллагчид) орцод ногдох гарцын хэмжээгээр тодорхойлно. Өөрөөр хэлбэл нэгж ажиллагчид ногдох ДНБ (нэмэгдэл өртөг) -ий хэмжээгээр тодорхойлно.

Тооцох аргачлал:

$$P = \frac{Y}{N} = \frac{\text{Дотоодын Нийт Бүтээгдэхүүн (зэрэгцүүлсэн үнээр)}}{\text{Ажиллагсдын тоо}}$$

- P- Хөдөлмөрийн бүтээмж
- Y-Дотоодын нийт бүтээгдэхүүн(зэрэгцүүлэх үнээр)
- N- Ажиллагчдын тоо

ГУРАВ. СУДАЛГААНЫ ХЭСЭГ**3.1. Хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчийг тодорхойлох үзүүлэлтүүд:**

Эдийн засгийн ачаалал нь (ЭЗА) тухайн улс орны эдийн засгийн ачааллыг харуулдаг гол үзүүлэлт юм. Тухайлбал, эдийн засгийн ачаалал бага байх тусам эдийн засгийн идэвхгүй хүн амын тоо нь эдийн засгийн идэвхтэй хүн амын тооноос төдий чинээ цөөн байгааг харуулж байна. Хэнтий аймгийн хувьд эдийн засгийн ачааллыг тооцож харуулбал:

Эдийн засгийн ачаалал:

$$\text{ЭЗА} = \frac{18311}{35425} \times 100\% = 51.7\%$$



Эдийн засгийн ачааллыг тооцож үзэхэд 51.7% гарч байгаа нь эдийн засгийн ачаалал өндөр байгааг илэрхийлж байна. Иймд эдийн засгийн идэвхтэй хүн амын тоо нь эдийн засгийн идэвхгүй хүн амын тооноос өндөр байна.

Сүүлийн 5 жилийн байдлаар харвал Хэнтий аймгийн эдийн засгийн ачаалал тогтвортой биш, өсч буурч байгаа харагдаж байна. Үүнд хүн амын эдийн засгийн идэвхгүй хүн амын тоо өсч, буурч байгаа нь нөлөөлж байна.


3.1.1. Ажил эрхлэлтийн үндсэн үзүүлэлтүүд:**Зураг 1: АЖИЛ ЭРХЛЭЛТИЙН ХОЛБОГДОЛТОЙ ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД**

Хэнтий аймагт 2015 оны жилийн эцсийн байдлаар 23.5 мянган өрхөд 72.3 мянган хүн амьдарч байгаагийн 27.6 хувь нь аймгийн төвд, 37.3 хувь нь сумын төв, тосгонд, 35.1 хувь нь хөдөө амьдарч байна.

Хүн амын үндсэн бүтцийг харуулбал 2015 оны эцсийн байдлаар аймгийн хөдөлмөрийн насны хүн ам нь нийт хүн амын 63.3 хувийг эзэлж байгаа бөгөөд нийт хүн амын 32.0 хувь нь 16 хүртэлх насны хүүхэд байгаа юм. 49.0 хувь нь эдийн засгийн идэвхтэй хүн ам буюу ажиллах хүч байна. Нийт суурин хүн амын тоо өнгөрсөн оныхоос 1.8 хувиар буюу 1274 хүнээр өсөж, хөдөлмөрийн насны хүн амын тоо 0.1 хувиар буюу 30 хүнээр тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Аймгийн хэмжээнд 2000 онд 1000 хүнд ногдох төрөлт 21.9 байсан бол 2005 онд 17.5, 2010 онд 19.8, 2012 оны эцэст 21.1, 2013 онд 23.9 болсон байна. 2014 онд 28.0, 2015 онд 22.8 болж өмнөх онуудаас буурсан байна.

Хүн амын суваргаас харахад төрөлт өндөр байх үеийн өсөлт нь хөдөлмөрийн насны хүн амын өсөлтөд ихээхэн нөлөөлж байгаа ба хөдөлмөрийн насны хүн амын жилийн дундаж өсөлт хүн амын дундаж өсөлтөөс өндөр хэвээр байна.



Хүснэгт 1: ХҮН АМЫН АЖИЛ ЭРХЛЭЛТИЙН ҮЗҮҮЛЭЛТ

	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015
Нийт хүн ам	68.1	68.9	67.8	70.2	70.1	70.8	70.2	69.2	71.1	72.3
Хөдөлмөрийн насны хүн	41.2	42.0	42.0	42.0	42.6	43.1	43.8	45.6	45.8	45.8
Эдийн засгийн идэвхтэй хүн	28.1	27.4	27.5	23.7	23.7	28.7	32.2	33.4	32.1	35,4
Ажиллагчид	26.6	26.5	26.5	26.5	24.9	26.2	28.0	27.6	26.5	30,5
Бүртгэлтэй Ажилгүйчүүд	1.4	0.9	1.1	0.9	1.0	1.3	1.1	1.1	1.1	1.1



Манай аймгийн нийт хүн ам 2006 оноос хойш дунджаар 69.9 мянган хүнээр өсч, эдийн засгийн идэвхтэй хүн ам 29.2 мянган хүнээр нэмэгджээ. Мөн ажиллагчдын тоо сүүлийн 10 жилийн байдлаар дунджаар 27.0 мянган хүн тус тус болсон байна.

Зураг 2: ХӨДӨЛМӨРИЙН НАСНЫ ХҮН АМЫН ТОО, аймаг, 2006-2015 оноор



Аймгийн хэмжээнд хөдөлмөрийн насны хүн амыг 2006-2015 оны байдлаар харууллаа. Энэ 10 жилийн хугацаанд хөдөлмөрийн насны хүн ам дунджаар 4.6 мянган хүнээр өссөн байна. 2015 оны байдлаар 45767 болсон нь өмнөх оноос 30 хүнээр буюу 0.1 хувиар буурсан байна.

Манай аймгийн хувьд хөдөлмөрийн насны хүн амын тоо 2006-2015 оны хооронд өссөн үзүүлэлттэй байна. 2006 онд 41.2 мянган хүн байсан бол 2008 онд 42.0, 2010 онд 42.6, 2011 онд 43.1, 2012 онд 43.8, 2013 онд өсч хөдөлмөрийн насны хүн амын тоо 45.6 мянга болсон бол 2014 онд 45.8 мянга, 2015 онд 45.8 өмнөх онтой адил үзүүлэлт гарлаа.

Нийт хүн амын 16-24 насны залуучууд 2015 оны байдлаар 15.4 хувийг эзэлж байгаа бол 25-34 насны залуучууд 16.2 хувийг эзэлж байна.

3.1.2. Эдийн засгийн идэвхтэй хүн ам, ажиллах хүчний оролцооны түвшин, ажил эрхлэлт, ажилгүйдлийн түвшин:

Хүснэгт 2: ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХТЭЙ ХҮН АМЫН ТОО, хүйс, бүс, аймаг, нийслэлээр


Аймаг	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015
Улсын дүн	1071555	1127902	1147144	1124711	1151146	1198333	1206554	1243895
Зүүн бүс	73985	76948	80364	86246	89875	88828	88517	96694
Дорнод	22982	24328	26212	28915	27645	29043	28679	31661
Сүхбаатар	23465	28899	30469	28639	29973	26400	27708	29608
Хэнтий	27538	23721	23683	28691	32257	33385	32130	35425
Улаанбаатар	398212	387992	395149	382810	393315	447293	47138	7494106

Эдийн засгийн идэвхтэй хүн ам буюу ажиллах хүчинд үндэсний тооцооны системийн хүрээнд, хөдөлмөрийн насанд хүрсэн, ажил хийх чадвартай ажиллах хүчээ нийлүүлж байгаа ажиллагчид болон хөдөлмөрөө нийлүүлэхэд бэлэн байгаа ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй иргэдийг хамруулдаг. Эдийн засгийн тухайн үеийн идэвхтэй хүн ам буюу ажиллах хүчийг сүүлийн 7 хоногт ажил эрхэлж байсан болон ажил эрхлээгүй боловч ажил эрхлэхэд бэлэн байсан, ажил хөдөлмөр идэвхтэй хайсан, ажилгүй байсан хүн ам бүрдүүлдэг.


Зүүн бүс нь 2015 оны байдлаар улсын нийт эдийн засгийн идэвхтэй хүн амын 7.8 хувийг эзэлж байгаа бол манай аймгийн хувьд бүсдээ 36.6 хувийг эзэлж байна. 2014 онд 36.3 хувьтай байсан бол энэ онд 0.3 пунктээр өссөн үзүүлэлттэй байна.

15, ба түүнээс дээш насны эдийн засгийн идэвхтэй хүн амын тоог зүүн бүсийн аймгуудтай харьцуулахад Сүхбаатар аймгаас 6.0 пунктээр, Дорнод аймгаас 3.9 пунктээр тус тус их байгаа харагдаж байна.

Зураг 3: ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХТЭЙ ХҮН АМЫН ТОО, бүсээр, 2014 оноор



Зураг 4: ХҮН АМЫН АЖИЛ ЭРХЛЭЛТИЙН ҮЗҮҮЛЭЛТЭД ГАРСАН ӨӨРЧЛӨЛТ




Хэнтий аймгийн хувьд ажиллагчид 2012 оноос 2013 онд 1.4 хувиар, 2013 оноос 2014 онд 4.0 хувиар буурч, 2015 онд өмнөх оноос 15.1 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Энэ нь зах зээлийн үед ажлын байр хумигдаж байсан бол 2015 онд Хэнтий аймгийн хувьд бүтээн байгуулалтын ажил их хийсэнтэй холбоотой. Ажилгүйчүүдийг авч үзвэл 2010 онд 990 хүн байсан бол 2011 онд 2493 хүн болж өмнөх оноос 1503 хүнээр өссөн 2012 онд өмнөх оноос 1713 хүнээр буюу 68.7 хувиар, 2013 онд 1620 хүнээр буюу 38.5 хувиар тус тус өсөж харин 2014 онд өмнөх оноосоо 148 хүнээр буюу 2.5 хувиар, 2015 онд өмнөх оноосоо 727 хүнээр буюу 12.8 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй гарчээ. Энэ нь ажилгүйчүүдийн тоо жилээс жилд өсч байгаач манай аймгийн хувьд сүүлийн 2 жил буурсан нь сайшаалтай.

Ажиллах хүчний оролцооны түвшин

Үндэсний хөгжлийн цогц бодлогын болон Монгол улсын Мянганы хөгжлийн зорилтын шалгуур үзүүлэлтэд “Хүн амын хөдөлмөр эрхлэлтийн түвшинг дээшлүүлж, хөдөлмөрийн зах зээлд шилжин буй залуучуудын ажилгүйдлийн түвшинг бууруулах” зорилтын хүрээнд ажиллах хүчний оролцооны түвшинг тооцоолсон байна.

Манай аймгийн хувьд ажиллах хүчний оролцооны түвшин 2015 онд 65.9 хувьд хүрсэн байна. Хэнтий аймгийн АХОТ, бүсийн АХОТ-ээс 0.3 пунктээр дээгүүр байгаа бол Сүхбаатар аймгаас 10.2 пунктээр бага, Дорнод аймгаас 8.2 пунктээр их байна. Харин улсын дунджаас 4.4 пунктээр их байна.

Зураг 5: АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, бүсээр, хүйсээр, 2015 оноор



Дээрх зурагт 2015 оны жилийн эцсийн байдлаар ажиллах хүчний оролцооны түвшинг хүйсээр харуулсан байна. Улс, бүсийн хэмжээнд эрэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин илүү байгаа ба энэ нь эрэгтэйчүүдийн ажил эрхлэлт эмэгтэйчүүдээс илүү байгаа нь харагдаж байна.

Зураг 6: ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТҮВШИН, хувиар, 2007-2015 оноор




Хэнтий аймгийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин 2007-2009 онуудад ижил түвшинд байсан бол 2010 оноос эхэлж буурсаар 2012 онд 1.2 пунктээр, 2013 онд 0.1 пунктээр тус тус өсч 2014 онд 55.7 хувьд хүрч буурсан бол 2015 онд 1.0 пунктээр өсчээ.

Энэ нь улсын хэмжээний ХЭТ-ээс 0.2 пунктээр доогуур байгаа бол бүсийн ХЭТ-ээс 1.9, Сүхбаатар аймгаас 12 пунктээр доогуур, Дорнод аймгаас 3.5 пунктээр их гарсан үзүүлэлттэй байна.

Зураг 7: АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, АЖИЛГҮЙДЛИЙН ТҮВШИН

Манай аймгийн хувьд ажилгүйдлийн түвшин 2014 оны байдлаар 17.7% нь ажилгүй байсан бол 2015 онд ажилгүйдлийн түвшин 14.0 % болж өмнөх оныхоос 3.7 пунктээр буурсан дүнтэй байна. Энэ нь эдийн засгийн идэвхитэй хүн амын 14.0 хувь нь ажилгүй байгааг харуулж байна. Мөн улсын АТ-тэй харьцуулахад 6.5, бүсийн хэмжээнд Сүхбаатар аймгаас 6.1 пунктээр, Дорнод аймгаас 4.3 пунктээр их байна. Ажилгүйдлийн түвшин Баян-Өлгий, Говь-Алтай, Увс, Ховд, Дархан-Уул, Говьсүмбэр, Дорноговь, Өмнөговь, Дорнод, Хэнтий, Сүхбаатар аймгуудад 0.4 – 9.0 пунктээр улсын түвшнээс их байгаа бол бусад аймагт 0.6-5.3 пунктээр доогуур байна.



Хүснэгт 4: АЖИЛГҮЙДЛИЙН ТҮВШИН, бүс, аймаг, хүйсээр

Аймаг	Хүйс	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015
Улсын дүн	Бүгд	2.8	11.6	9.9	7.7	8.2	7.9	7.9	7.5
	Эрэгтэй	2.3	11.6	10.5	8.1	8.4	7.6	8.5	8.2
	Эмэгтэй	3.2	11.6	9.2	7.4	8.1	8.3	7.3	6.7
Зүүн бүс	Бүгд	3.6	9.1	10.5	11.1	10.8	11.2	13.1	10.7
	Эрэгтэй	2.7	9.1	9.5	10.4	11.3	11.4	13.9	12
	Эмэгтэй	4.6	9.1	11.6	11.8	10.2	11	12.1	9.3
Дорнод	Бүгд	4	2.5	12.3	10.9	8.1	7.9	10.8	7.9
	Эрэгтэй	2.1	2.3	12.9	12.6	8.4	8	11.4	7.7
	Эмэгтэй	5.9	2.8	11.5	8.8	7.8	7.7	10.1	8.2
Сүхбаатар	Бүгд	3	16	13.8	13.7	10.7	7	10.1	9.7
	Эрэгтэй	2.5	14.6	10.8	10.7	11.5	6.2	10.4	11.2
	Эмэгтэй	3.5	17.6	17.1	16.8	9	8	9.8	8.2
Хэнтий	Бүгд	3.9	7.3	4.2	8.7	13	17.5	17.7	14.0
	Эрэгтэй	3.4	9.1	3.4	7.9	13.6	18.6	19.3	16.6
	Эмэгтэй	4.4	5.5	5	9.6	12.5	16.2	15.9	11.1

Хэнтий аймгийн ажилгүйдлийн түвшин 2007-2009 онд 3.9 пунктээр өссөн байсан бол 2010 онд 3.0 пунктээр буурчээ. 2011 оноос өсөж 2014 оны жилийн эцэст 17.7 хувьд хүрсэн бол 2015 оны байдлаар 14.0 байгаа нь өмнөх оны АТ-ээс 3.7 пунктээр буурсан байна.

Зүүн бүсийн хувьд эмэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшинг улсын эмэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшингийн дундажтай харьцуулахад 2.6 пунктээр их байна. Харин манай аймгийн эмэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин улсын эмэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшний дунджаас 4.4, Сүхбаатар аймгийн эмэгтэйчүүдээс 2.9 пунктээр, Дорнод аймгийн эмэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшингээс 2.9 пунктээр тус тус их байна.

Хүснэгт 5: СУДАЛГААНД ХАМРАГДСАН ХҮН АМЫН ТОО, насны бүлэг, байршлаар

	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Хот			Хөдөө		
				Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
Бүгд	37318	39256	76574	9679	9922	19601	27639	29334	56974
Нас									
0 - 4	4270	4012	8282	1014	1037	2051	3256	2976	6231
5 - 9	3743	4168	7911	812	1237	2049	2932	2931	5862
10 - 14	3291	3354	6646	966	709	1674	2326	2646	4971
15 - 19	3434	3074	6508	1002	811	1813	2433	2263	4696
20 - 24	3096	2850	5946	1021	697	1717	2076	2153	4229
25 - 29	2857	2915	5772	795	902	1698	2062	2012	4074
30 - 34	2745	3093	5838	529	586	1114	2217	2507	4724
35 - 39	2512	2838	5350	476	474	950	2036	2364	4400
40 - 44	2856	3024	5880	648	919	1567	2208	2105	4313
45 - 49	2824	3066	5890	652	810	1462	2172	2257	4428
50 - 54	1652	2649	4301	597	743	1340	1055	1906	2961
55 - 59	2009	1616	3625	684	512	1196	1325	1104	2430
60 - 64	655	1063	1718	171	318	490	484	745	1228
65 - 69	579	358	937	110	54	164	469	304	773
70 +	794	1176	1970	204	113	317	590	1062	1653
5 - 9	3743	4168	7911	812	1237	2049	2932	2931	5862
10 - 11	1279	1363	2642	322	375	697	957	988	1945
12 - 14	2012	1991	4004	644	333	977	1369	1658	3026
15 - 17	2466	2011	4477	741	539	1280	1725	1472	3197
5 - 17	9501	9533	19034	2518	2484	5002	6983	7049	14031
5 +	33049	35244	68292	8665	8885	17550	24384	26359	50743
15 +	26014	27722	53736	6887	6939	13827	19126	20783	39909
15 - 59	23986	25125	49110	6403	6453	12856	17583	18671	36254

Ажиллах хүчний судалгаанд 2015 онд манай хэмжээнд нийт 76.6 мян хүн хамрагдсан байна. Судалгаанд хамрагдсан иргэдийг хүйсээр авч үзвэл 51.3 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. Харин насны бүлгээс харахад 35-39 насныхан судалгаанд их хамрагдсан байна. 60-64 насныхан хамрагдалтын хувьд хамгийн бага буюу 2.7 хувьтай байна.

Байршлын хувьд хөдөөд судалгаанд хамрагдсан иргэдийн тоо илүү буюу нийт хамрагдсан иргэдийн 74.4 хувийг эзэлж байна. Энэ нь хамрагдах нэгжийн хувьд хөдөөд илүү өрх сонгогддогтой холбоотой.


3.1.3. Ажиллагчдын тоо, хүйс, насны бүлэг, боловсролын түвшин, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, байгууллагын төрөл, ажил мэргэжлийн ангиллаар:

Хүснэгт 6: АЖИЛЛАГЧДЫН ТОО, бүсээр

	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015
Зүүн бүс	71305	69972	71956	76702	80207	78853	76941	86353
Дорнод	22065	23709	22990	25774	25400	26750	25575	29155
Сүхбаатар	22769	24274	26273	24729	26756	24544	24914	26724
Хэнтий	26471	21989	22693	26199	28051	27559	26452	30474

Ажиллагчдын тоо зүүн бүсийн хувьд 2008-2009 онуудад буурсан бол 2010-2012 онуудад өссөөр, 2013 онд 78.9 мянган хүн болсон байна. Хэнтий аймгийн хувьд 2015 онд ажиллагчдын тоо 30.5 мянга болж өмнөх оны ажиллагчдын тооноос 15.1 хувиар өсчээ. Аймгийн нийт ажиллагчид улсын хэмжээнд 2.6 хувийг, бүсийн хэмжээнд 35.3 хувийг эзэлж байна. Энэ нь 4022 хүнээр өссөн байна. Аймагт шинэ болон түр ажлын байр нэмэгдэж бүтээн байгуулалтын ажил их хийгдсэнтэй холбоотой. Зүүн бүсийн хэмжээнд 2015 онд 35.3 хувийг эзэлж байгаа нь өмнөх оноос 0.9 пунктээр өссөн байна. Аймгийн нийт ажиллагчдын 15.1 мян хүн буюу 49.5 хувийг эмэгтэйчүүд эзэлж байгаа ба улсын нийт эмэгтэй ажиллагчдын 2.8%, зүүн бүсийн 36.3 хувийг эзэлж байна. Харин Сүхбаатар аймгаас 2156 хүнээр, Дорнод аймгаас 1535 хүнээр тус тус их байна. Судалгааны үр дүнгээс харахад эмэгтэй ажиллагчид улс, бүсүүдийн хувьд эрэгтэй ажиллагчдаас доогуур хувьтай байгаа харагдаж байна. Харин аймгийн нийт ажиллагчдын хүйсийн хувьд эрэгтэй ажиллагчид давамгайлж байгаа ба улсын хэмжээнд ч мөн адил эрэгтэйчүүдийн ажил эрхлэлт илүү байна. Хэнтий аймгийн эрэгтэй ажиллагчид нийт ажиллагчдын 50.5 хувийг, улсын 2.5%, бүсийн 34.4 хувийг тус тус эзэлж байна.

Зураг 8: АЖИЛЛАГЧДЫН ТОО, бүс, хүйсээр, 2015 оноор



Манай аймгийн хувьд ажиллагчдын тоо эрэгтэйчүүдийн хувьд 2007-2011 он хүртэл өсч байсан бол 2014 онд 13757, 2015 онд 15394 болж өмнөх оноос өссөн. Харин 2015 онд аймгийн нийт ажиллагчдын тоо 30474 мянган хүн болж өссөн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 4022 хүнээр нэмэгдсэн байна.

Хүснэгт 7 : АЖИЛЛАГЧИД, хүйс, боловсролын түвшин, байршлаар, 2015 оноор

	Бүгд	Хүйс		Байршил					
		Эрэгтэй	Эмэгтэй	Хот			Хөдөө		
				Бүгд	Хүйс		Бүгд	Хүйс	
					Эрэгтэй	Эмэгтэй		Эрэгтэй	Эмэгтэй
Бүгд	30473	15394	15080	6303	2941	3363	24170	12453	11717
Боловсролгүй	1019	757	262	53	53	0	966	704	262
Бага	2303	1617	686	273	215	59	2029	1402	627
Суурь	3304	2117	1186	267	212	54	3037	1905	1132
Бүрэн дунд	5394	1705	3688	521	97	425	4872	1608	3264
Техникийн болон мэргэжлийн	8816	6170	2646	1832	1239	593	6984	4931	2053
Тусгай мэргэжлийн дунд	2446	818	1628	756	222	534	1691	597	1094
Дипломын дээд болон бакалавр	7079	2208	4871	2548	903	1645	4532	1305	3226
Магистр	113	0	113	53	0	53	59	0	59

Аймгийн нийт ажиллагчдыг 2015 онд боловсролын түвшнээр авч үзвэл хамгийн их хувийг техникийн болон мэргэжлийн боловсролтой иргэд 8816 буюу нийт ажиллагчдын 28.928.9%, дипломын болон бакалавр 7079 буюу 23.2%, бүрэн дунд боловсролтой 5394 буюу 17.7%-ийг тус тус эзэлж байгаа бол хамгийн бага хувийг боловсролгүй иргэд 1019 буюу 3.3 хувийг эзэлж байна. Магистр цолтой ажиллагчид нийт ажиллагчдын 0.4 хувь байна.

Хэнтий аймгийн нийт ажиллагчдын 49.5 хувийг эмэгтэйчүүд эзэлж байгаа бол дипломын болон бакалаврын дээд боловсролтой эмэгтэйчүүд 32.3 хувийг, техникийн болон мэргэжлийн боловсролтой эмэгтэйчүүд нийт эмэгтэй ажиллагчдын 17.5 хувийг эзэлж байна.

Аймгийн хэмжээнд 2015 оны байдлаар нийт ажиллагчдын 79.3 хувийг хөдөө ажиллагчид эзэлж байна. Хөдөө ажиллагч эмэгтэйчүүд нийт ажиллагчдын 38.5%, нийт эмэгтэй ажиллагчдын 77.7%-ийг тус тус эзэлж байна.


Хүснэгт 8: АЖИЛЛАГЧИД, хүйс, эдийн засгийн салбараар, байршлаар, 2015 оноор

	Бүгд	Хүйс		Байршил					
		Эрэгтэй	Эмэгтэй	Хот			Хөдөө		
				Бүгд	Хүйс		Бүгд	Хүйс	
					Эрэгтэй	Эмэгтэй		Эрэгтэй	Эмэгтэй
Бүгд	30473	15394	15080	6303	2941	3363	24170	12453	11717
ХАА, ойн аж ахуйн, загас	15259	8923	6336	801	585	216	14458	8338	6120

барилт, ан агнуур									
Уул уурхай, олборлолт	1547	949	598	0	0	0	1547	949	598
Боловсруулах үйлдвэрлэл	834	528	306	264	216	48	569	312	257
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	318	217	101	158	158	0	160	59	101
Усан хангамж, бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент б	263	210	53	263	210	53	0	0	0
Барилга	555	402	153	206	103	103	349	299	50
Бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилг	3269	1013	2256	811	217	595	2458	797	1662
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	485	385	99	216	167	48	269	218	51
Зочид буудал, байр сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	808	0	808	499	0	499	309	0	309
Мэдээлэл, холбоо	164	0	164	109	0	109	55	0	55
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	309	48	260	102	48	53	207	0	207
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	318	154	164	155	48	107	163	106	57
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	104	104	0	55	55	0	49	49	0
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын	2240	1286	954	1186	700	485	1054	586	468
Боловсрол	2208	532	1675	652	117	534	1556	415	1141
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	1109	267	842	410	103	307	699	164	535
Урлаг, үзвэр, тоглоом наадам	311	160	150	199	48	150	112	112	0
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	325	166	160	219	166	53	106	0	106
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа	49	49	0	0	0	0	49	49	0

Аймгийн хэмжээний нийт ажиллагчдын тоог сүүлийн жилээр харахад 6 салбарын ажиллагчид байнгын их ажиллах хүчний хувийг эзэлдэг нь харагдаж байна. 2015 оны байдлаар нийт ажиллагчдын хамгийн өндөр буюу 50.1 хувийг хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын салбарт ажиллагчид эзэлж байгаа бол бөөний болон жижиглэн худалдааны салбарт ажиллагчид 10.7 хувийг эзэлж байна.

Зураг 9: АЖИЛЛАГЧИД, салбараар, аймгаар /хамгийн их ажиллагчидтай/, 2015 оноор



Төрийн захиргаанд ажиллагсад 7.4%, боловсролын салбарт 7.2%, уул уурхайн салбарт 5.1%, эрүүл мэндийн салбарт 3.6 хувийг тус тус эзэлж байна.

Хамгийн бага буюу 0.2 хувийг хүн хөлсөн ажиллуулдаг өрхийн үйл ажилаагаа, 0.9 хувийг Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны ба мэдээлэл холбооны салбарт ажиллагсад эзэлж байна. Эмэгтэй ажиллагчдыг салбар, байршлаар авч үзвэл хөдөө аж ахуйн салбарт ажиллагчид нийт эмэгтэй ажиллагчдын 42.0%, бөөний болон жижиглэнгийн худалдааны салбарт 15.0%-ийг тус тус эзэлж байна.

Хөдөөгийн, хөдөө аж ахуйн салбарт ажиллагч эмэгтэйчүүд нийт эмэгтэй ажиллагчдын 40.6%, хөдөөгийн нийт эмэгтэйчүүдийн 52.2%, ХАА-н салбарт ажилладаг нийт эмэгтэй ажиллагчдын 96.6 хувийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 9 : АЖИЛЛАГЧИД, хүйс, хөдөлмөр эрхлэлтийн статус, байршлаар, 2015 оноор

	Бүгд	Хүйс		Байршил					
		Эрэгтэй	Эмэгтэй	Хот			Хөдөө		
				Бүгд	Хүйс		Бүгд	Хүйс	
					Эрэгтэй	Эмэгтэй		Эрэгтэй	Эмэгтэй
Бүгд	30473	15394	15080	6303	2941	3363	24170	12453	11717
Цалин хөлстэй ажиллагч	10954	4871	6083	4057	1820	2237	6897	3051	3846
Ажил олгогч	532	164	368	168	110	59	364	55	309
Хувиараа хөдөлмөр эрхлэгч	4527	2021	2506	1335	483	852	3192	1538	1654
Нөхөрлөл, хоршооны гишүүн	107	107	0	107	107	0	0	0	0
Мал аж ахуй эрхлэгч	14196	8127	6069	582	421	161	13614	7706	5908
Өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогч	157	103	54	54	0	54	103	103	0

Хөдөлмөр эрхлэлтийн статусаар авч үзвэл цалинтай хөлстэй ажиллагчид 11.0 мян хүн, мал аж ахуй эрхлэгчид 14.2 мян хүн, хувиараа хөдөлмөр эрхлэгчид 4.5 мян хүн байгаа ба нөхөрлөл хоршоололд 107 хүн ажиллаж байгаа нь хамгийн бага ажиллагчтай байна. Харин хөдөөд цалин хөлстэй ажиллагчид нийт цалин хөлстэй

ажиллагчдын 63.0 хувийг эзэлж байгаа бол мал аж ахуй эрхлэгчид 46.6 хувийг эзэлж байна.

Хот, хөдөөд эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүд мал аж ахуй, цалин хөлстэй ажиллагчид өндөр хувийг эзэлж байна.

Зүүн бүсийн хувьд улсын хэмжээний нийт ажиллагчдын 7.5 хувийг эзэлж байгаа бол Хэнтий аймаг улсын нийт ажиллагчдын 2.6%, зүүн бүсийн 35.3%, Сүхбаатар аймгийн ажиллагчдаас 3750 хүнээр, Дорнод аймгийн нийт ажиллагчдаас 1319 хүнээр тус тус их байна.

Хэнтий аймгийн ажиллагчдын тоо 2010 оноос 7.8 мянган хүнээр, 2012 оноос 2.4 мянган хүнээр тус тус өссөн харагдаж байна. Харин 2015 оны хувьд өмнөх оноос 4.0 мянган хүнээр өссөн үзүүлэлттэй гарлаа.

Хүснэгт 10: АЖИЛЛАГЧИД, хүйс, ажил мэргэжлийн ангиллаар, байршлаар, 2015 оноор

	Бүгд	Хүйс		Байршил					
		Эрэгтэй	Эмэгтэй	Хот			Хөдөө		
				Бүгд	Хүйс		Бүгд	Хүйс	
					Эрэгтэй	Эмэгтэй		Эрэгтэй	Эмэгтэй
Бүгд	30473	15394	15080	6303	2941	3363	24170	12453	11717
Менежер	1719	727	992	382	163	219	1337	564	773
Мэргэжилтэн	3723	1098	2625	1528	476	1052	2195	622	1573
Техникч болон туслах/ дэд мэргэжилтэн	530	214	316	369	214	155	160	0	160
Контор, үйлчилгээний ажилтан	704	114	590	274	0	274	429	114	316
Худалдаа, үйлчилгээний ажилтан	4336	927	3409	1555	318	1236	2781	609	2172
Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын мэргэшсэн ажилтан	15037	8759	6278	691	475	216	14346	8284	6062
Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажил	1228	822	407	257	209	48	971	613	358
Машин механизм, төхөөрөмжийн операторч, угсрагч	1475	1427	48	649	649	0	826	778	48
Энгийн ажил, мэргэжил	1721	1305	416	598	436	162	1123	869	254

Аймгийн нийт ажиллагчдыг ажил мэргэжлийн ангиллаар авч үзвэл нийт ажиллагчдын 49.3% нь хөдөө аж ахуйн салбарт ажиллаж байгаа бол тус салбарт ажиллаж байгаа эмэгтэйчүүд 20.6%-ийг эзэлж байна. Энэ нь хамгийн их ажиллагчтай салбар бөгөөд улсын хэмжээнд ХАА-н салбарт ажиллагчид 2.7%-ийг эзэлж байна. Байршлын хувьд хөдөө ажиллагчид хөдөө аж ахуйн салбарт их байгаа бол хотод худалдаа, үйлчилгээний салбарт ажиллагчид их байна. Хотын эмэгтэйчүүд худалдаа

үйлчилгээний болон төрийн байгууллагад их ажиллаж байгаа бол хөдөөгийн эмэгтэйчүүд хөдөө аж ахуй болон төрийн байгууллагад их ажиллаж байна.

Харин насны бүлгийн хувьд 40-44 насныхан аймгийн нийт ажиллагчдын 16.5%-ийг эзэлж байгаа нь хамгийн өндөр байна. 30-34 насны ажиллагчид 14.3%, 35-39 насныхан 13.8%-ийг тус тус эзэлж байна. 15-19 болон 70 дээш насны иргэдийн ажил эрхлэлт хамгийн бага бага буюу 2.0 хувьтай байна.

Хөдөөд 40-44, 35-39, 30-34 насныхны ажил эрхлэлт өндөр байгаа бол хотод 25-29, 30-34, 40-44 насныхан нийт хотод ажил эрхлэгчдийн 13.3% - 18.8% -ийг эзэлж байна.

Хүснэгт 11: АЖИЛЛАГЧИД, хүйс, насны бүлэг, байршлаар

	Бүгд	Хүйс		Байршил					
		Эрэгтэй	Эмэгтэй	Хот			Хөдөө		
				Бүгд	Хүйс		Бүгд	Хүйс	
					Эрэгтэй	Эмэгтэй		Эрэгтэй	Эмэгтэй
Бүгд	30473	15394	15080	6303	2941	3363	24170	12453	11717
Нас 15 - 19	403	403		54	54		349	349	
20 - 24	2546	1552	995	314	55	259	2232	1497	735
25 - 29	3987	2281	1706	1165	686	479	2822	1595	1227
30 - 34	4367	2168	2199	841	474	367	3526	1694	1832
35 - 39	4212	1992	2220	523	265	258	3688	1727	1962
40 - 44	5022	2371	2651	1188	378	810	3834	1994	1841
45 - 49	3876	1501	2374	700	161	539	3175	1340	1835
50 - 54	2776	1116	1660	758	328	430	2017	788	1230
55 - 59	2055	1313	742	475	368	107	1580	945	635
60 - 64	772	442	329	176	117	59	596	325	271
65 - 69	260	155	105	109	55	54	151	100	51
70 +	198	99	99				198	99	99

Хэнтий аймгийн ажиллагчдыг насны бүлгээр авч үзвэл 40-44 насныхан хамгийн өндөр буюу 16.5 хувь, 35-39 насныхан нийт ажиллагчдын 13.8%, 30-34 насныхан 14.3%, 25-29 насныхан 13.1%-ийг эзэлж байгаа нь хамгийн их хувьтай байна. Харин 15-19, 60-аас дээш насныхан хамгийн бага хувийг эзэлж байна.

Хүйсийн хувьд эмэгтэй, эрэгтэй ажиллагчдын хувьд мөн 40-44 насныхан өндөр хувьтай байна.

65-дээш насныхны хувьд эрэгтэй эмэгтэй ажиллагчид ойролцоо байгаа ба байршлын хувьд хот, хөдөө ажиллагсад ойролцоо тооны түвшинд байна.

3.2. Ажилгүйдэл:

3.2.1 Эдийн засгийн идэвхгүй хүн ам, ажилгүйчүүдийн тоо, хүйс, насны бүлэг, боловсролын түвшин, ажилд орсон байгууллагын төрөл, ажилгүйдлийн шалтгаан:

Улсын хэмжээнд эдийн засгийн идэвхгүй хүн ам 2010 онд 716.2 мянган хүн байсан бол 2011-2012 онд 661 мянган хүн болтлоо буурсан ч 2015 онд 779.0 мянган хүн болж өссөн байна. Манай аймгийн хувьд эдийн засгийн идэвхгүй хүн амын тоо 2010 онд 27081, 2011 онд 26118, 2013 онд 15356 болж буурсан бол 2014 онд 18673 болж өссөн бол 2015 онд 18311 болж буурсан байна. Аймгийн нийт ЭЗИ-гүй хүн ам улсын ЭЗИ-гүй хүн амын 2.4%, бүсийн 36.1%-ийг эзэлж байна.

Энэ оны хувьд улсын эдийн засгийн идэвхгүй эмэгтэй хүн амд Хэнтий аймгийн ЭЗИ-гүй эмэгтэйчүүдийн эзлэх хувь 2.3 хувь байгаа бол зүүн бүсийн ЭЗИ-гүй эмэгтэйчүүдийн 34.6 хувийг эзэлж байна.

Аймгийн нийт ЭЗИ-гүй хүн амыг насны бүлгээс харахад 15-19, 20-24 насныхан өндөр байгаа нь энэ насныхан ерөнхий боловсролын болон их, дээд сургуульд суралцдагтай холбоотой. 55-59 насныхан 8.0 хувьтай байгаа нь энэ насныхан тэтгэвэрт гардаг нь нөлөөлж байна.

**Хүснэгт 12 : ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХГҮЙ ХҮН АМ,
хүйс, насны бүлэг,байршлаар, 2015 оноор**

	Бүгд	Хүйс		Байршил					
		Эрэгтэй	Эмэгтэй	Хот			Хөдөө		
				Бүгд	Хүйс		Бүгд	Хүйс	
					Эрэгтэй	Эмэгтэй		Эрэгтэй	Эмэгтэй
Бүгд	18311	7551	10760	5586	2494	3092	12725	5057	7668
Нас 15 - 19	5947	2928	3019	1600	844	756	4347	2084	2263
20 - 24	2013	688	1326	761	380	381	1253	308	945
25 - 29	1325	324	1002	423	55	368	902	269	633
30 - 34	750	268	482	170		170	580	268	312
35 - 39	573	154	419	264	102	162	309	52	257
40 - 44	481	211	270	216	162	55	264	49	215
45 - 49	994	571	423	378	162	216	616	410	207
50 - 54	1363	433	930	468	214	254	895	219	676
55 - 59	1469	643	826	619	263	356	849	380	469
60 - 64	947	213	734	314	54	260	633	158	474
65 - 69	677	424	253	55	55		622	369	253
70 +	1772	695	1077	317	204	113	1455	491	964

Хөдөөд эрэгтэй ЭЗИ-гүй хүн ам суралцагчдыг тооцохгүйгээр 45-49 насныхан их байгаа бол эмэгтэйчүүдийн хувьд 50-54 насныхны эзлэх хувь их байна.

Харин хотынхны хувьд мөн суралцагчид, оюутнуудыг оролцуулахгүйгээр харвал 50-59 насныхан өндөр байгаа харагдаж байна.

**Хүснэгт 13: ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХГҮЙ ХҮН АМ,
хүйс, насны бүлэг, шалтгаанаар, 2015 оноор**

	Бүгд	Хүйс		Байршил					
		Эрэгтэй	Эмэгтэй	Хот			Хөдөө		
				Бүгд	Хүйс		Бүгд	Хүйс	
					Эрэгтэй	Эмэгтэй		Эрэгтэй	Эмэгтэй
Бүгд	18311	7551	10760	5586	2494	3092	12725	5057	7668
Гэрийн ажилтай	1544	850	694	967	478	489	577	372	206
Суралцдаг	6669	3085	3583	1868	1007	862	4801	2079	2722
Сурахаар явах гэж байгаа	167	55	113	108	55	53	59	0	59
Тэтгэвэрт	4037	1219	2818	866	259	608	3170	960	2210
Өндөр настан	585	213	373	164	54	110	422	158	263
Хөгжлийн бэрхшээлтэй	1343	737	606	266	157	108	1078	580	498
Ажил хийхийг хүсээгүй	322	322	0	102	102	0	220	220	0
Хүүхэд асарсан	1876	50	1826	549	0	549	1328	50	1278
Өвчтэй байсан	746	535	211	269	166	103	477	369	108
Өвчтөн, өндөр настан асарсан	371	110	260	212	55	157	158	56	103
Бусад	651	376	275	216	162	53	435	214	222

Аймгийн эдийн засгийн идэвхгүй хүн амыг хөдөлмөр эрхэлдэггүй шалтгаанаар дээрх хүснэгтэд харууллаа. Аймгийн нийт ЭЗИ-гүй хүн амын 36.4 хувийг суралцагчид, 22.0 хувийг тэтгэвэрийн насныхан эзэлж байгаа бол 10.2 хувийг хүүхэд асарсан, 8.4 хувийг гэрийн ажилтай иргэд эзэлж байгаа нь өндөр хувьтай үзүүлэлтүүд юм. Хамгийн бага хувьтай үзүүлэлтүүдийг харвал өндөр настнууд 3.2%, өвчтөн өндөр настан асарсан шалтгаанаар хөдөлмөр эрхлээгүй иргэд 2.0% тай байна.

Хүснэгт 14: АЖИЛГҮЙ ИРГЭД, бүс, аймгаар, онуудаар

	2010	2011	2012	2013	2014	2015
Улсын дүн	113438	87030	94705	37732	95856	92672
эмэгтэй	49698	38999	44392	47344	41513	38983
Зүүн бүс	8408	9544	9671	9975	11576	10341
эмэгтэй	4453	4747	4602	4543	4947	4238
Дорнод	3222	3141	2248	2293	3104	2506
эмэгтэй	1409	1165	1103	1028	1274	1209
Сүхбаатар	4196	3910	3217	1856	2794	2884
эмэгтэй	2451	2333	1464	968	1281	1147
Хэнтий	990	3493	4206	5826	5678	4951
эмэгтэй	593	1249	2035	2547	2392	1882

Зүүн бүс ажилгүй иргэдийн тоогоор 2015 онд улсын дүнгийн 11.2%-ийг эзэлж байгаа бол Хэнтий аймгийн ажилгүйчүүд зүүн бүсийн ажилгүйчүүдийн 47.9%-ийг эзэлж

байна. Нийт ажилгүй иргэдийн эзлэх хувь Сүхбаатар аймгаас 23.7 пунктээр, Дорнод аймгаас 20.0 пунктээр тус тус их байна.

Эмэгтэй ажилгүй иргэдийн тоо улсын нийт ажилгүй эмэгтэйчүүдийн 4.8%, зүүн бүсийн нийт ажилгүй эмэгтэйчүүдийн 44.4 хувийг эзэлж байгаа бол Сүхбаатар аймгийн ажилгүй эмэгтэйчүүдээс 673 ажилгүй эмэгтэй хүнээр, Дорнод аймгаас 735 ажилгүй эмэгтэйчүүдээр их гэсэн тоо гарсан байна.

Хүснэгт 15: АЖИЛГҮЙ ИРГЭД, хүйс, боловсролын түвшин, байршлаар, 2015 оноор

	Бүгд	Хүйс		Байршил					
		Эрэгтэй	Эмэгтэй	Хот			Хөдөө		
				Бүгд	Хүйс		Бүгд	Хүйс	
					Эрэгтэй	Эмэгтэй		Эрэгтэй	Эмэгтэй
Бүгд	4951	3069	1882	1937	1452	485	3014	1617	1397
Боловсролгүй	105	105	0	0	0	0	105	105	0
Бага	156	56	100	0	0	0	156	56	100
Суурь	616	318	298	276	221	54	341	97	244
Бүрэн дунд	851	488	363	320	217	103	531	272	260
Техникийн болон мэргэжлийн	1627	1317	310	712	598	113	915	718	196
Тусгай мэргэжлийн дунд	364	204	160	200	97	103	165	107	58
Дипломын дээд болон бакалавр	1231	580	651	431	319	111	801	261	539

Хэнтий аймгийн ажилгүй иргэдийг боловсролын түвшингээр авч үзвэл хамгийн өндөр хувийг техникийн болон мэргэжлийн боловсролтой ажилгүй иргэд 32.9 %, дипломын дээд болон бакалавр боловсролтой ажилгүй иргэд 24.9 %, бүрэн дунд боловсролтой ажилгүй иргэд 17,2%, эзэлж байна.

Боловсролгүй иргэд нийт ажилгүй иргэдийн 2.1 хувийг эзэлж байгаа нь хамгийн бага хувь байна.

Суурь болон бүрэн дунд боловсролтой ажилгүй иргэд мэргэжлийн боловсрол эзэмшээгүйгээс ажил олгогчийн шалгуурт тэнцэхгүй, мэргэжлийн боловсрол эзэмшсэн ажилгүй иргэдэд тохирох ажлын байр дутагдалтай нөхцөл байдал нөлөөлж байна.

Хүснэгт 16: АЖИЛГҮЙ ИРГЭД, хүйс, хүйс, насны бүлэг, 2015 оноор

	Бүгд	Хүйс		Байршил					
		Эрэгтэй	Эмэгтэй	Хот			Хөдөө		
				Бүгд	Хүйс		Бүгд	Хүйс	
					Эрэгтэй	Эмэгтэй		Эрэгтэй	Эмэгтэй
Бүгд	4951	3069	1882	1937	1452	485	3014	1617	1397
Нас 15 - 19	158	103	55	158	103	55			
20 - 24	1386	857	530	642	586	57	744	271	473
25 - 29	459	253	207	110	55	55	350	198	152
30 - 34	720	309	411	103	55	48	617	255	363
35 - 39	566	366	200	163	109	54	403	257	145

40 - 44	377	274	104	163	108	55	214	165	49
45 - 49	1020	751	269	383	329	54	637	422	215
50 - 54	162	103	59	113	55	59	48	48	
55 - 59	102	53	48	102	53	48			

Аймгийн нийт ажилгүй иргэдийн 18.7%-ийг 20-24 насны залуучууд, 25-29 насны ажилгүй иргэд 12.1%, 30-34 насныхан 11.9 хувийг эзэлж байна. Хөдөлмөр эрхэлдэггүй эмэгтэйчүүдийн хувьд мөн 20-24, 45-49 насныхан өндөр хувийг эзэлж байна.

Хөдөөд ажилгүй эмэгтэйчүүд мөн 20-24 насанд их байгаа бол хотод ажилгүй эмэгтэйчүүд 25-29 насныхан байна. Ажилгүй иргэдийн хамгийн бага хувийг 55-59 насныхан эзэлж байгаа ба энэ нь бүгд хот, хөдөөд ижил түвшинд байна.

Хүснэгт 17: БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, хүйс, бүс, аймаг, улсын дүн, оноор

		2010	2011	2012	2013	2014	2015
Улсын дүн	Бүгд	38250	57171	25776	42772	36970	32788
	эмэгтэй	20116	26043	18766	23470	20459	17720
Зүүн бүс	Бүгд	2736	3980	3439	4725	3230	2397
	эмэгтэй	1337	1918	1785	2373	1700	1282
Дорнод	Бүгд	786	1576	1634	2854	1636	1347
	эмэгтэй	435	797	761	1390	858	721
Сүхбаатар	Бүгд	907	859	780	763	745	432
	эмэгтэй	544	364	467	412	385	212
Хэнтий	Бүгд	1043	1365	1025	1108	849	618
	эмэгтэй	358	575	557	571	457	349

Улсын хэмжээнд нийт бүртгэлтэй ажилгүйчүүд өмнөх оноос 4182 хүнээр буурсан үзүүлэлтэй гарлаа. Зүүн бүсийн бүртгэлтэй ажилгүйчүүд улсын 7.3 хувийг эзэлж байгаа бол Хэнтий аймгийн нийт бүртгэлтэй ажилгүйчүүд зүүн бүсийн бүртгэлтэй ажилгүйчүүдийн 25.8 хувийг эзэлж байна. Энэ нь Сүхбаатар аймгаас 7.8 пунктээр их, Дорнод аймгаас 30.4 пунктээр бага байна.

Аймгийн бүртгэлтэй ажилгүй эмэгтэйчүүдийн хувьд улсын 2.0%, бүсийн бүртгэлтэй ажилгүй эмэгтэйчүүдийн 27.2% -ийг эзэлж байна. Харин Сүхбаатар аймгийн бүртгэлтэй ажилгүй эмэгтэйчүүдээс 10.7 пунктээр их, Дорнод аймгийн бүртгэлтэй ажилгүй эмэгтэйчүүдээс 29.0 пунктээр бага байна.

3.3. Бусад:

Хүснэгт 18: АЙМГИЙН АЛБАН БУС СЕКТОР ДАХЬ АЖИЛЛАГЧДЫН ТОО, хүйс, насны бүлэг, байршлаар, 2015 оноор

				Үндсэн	Давхар	
Бүгд	Бүгд			3065	439	
	Нас	25 - 29		253		
		30 - 34		316	218	
		35 - 39		667	56	
		40 - 44		471		
		45 - 49		618	117	
		50 - 54		221		
		55 - 59		411	48	
		60 - 64		59		
		65 - 69		49		
Хүйс	Эрэгтэй	Бүгд		1354	266	
		Нас	25 - 29		156	
			30 - 34		214	218
			35 - 39		153	
			40 - 44		206	
			45 - 49		101	
			50 - 54		167	
			55 - 59		250	48
			60 - 64		59	
	65 - 69		49			
	Эмэгтэй	Бүгд		1711	173	
		Нас	25 - 29		97	
			30 - 34		103	
			35 - 39		514	56
			40 - 44		265	
			45 - 49		518	117
			50 - 54		53	
			55 - 59		161	
Байршил			Хот		959	214
	Хөдөө		2106	225		

Аймгийн хэмжээний албан бус сектор дахь ажиллагчдын үндсэн болон давхар хөдөлмөр эрхлэлтийн байдлыг насаар нь авч үзэхэд 35-39 насныхан үндсэн ажлаараа албан бус хөдөлмөр эрхлэгчид хамгийн өндөр буюу 21.8 хувийг эзэлж байгаа бол эрэгтэйчүүдээс 55-59 насныхан хамгийн өндөр 8.2 хувийг, эмэгтэйчүүдийн хувьд 45-49 насныхан 16.9 хувийг эзэлж байгаа нь хамгийн өндөр байна.

Хөдөөд албан бус сектор дахь ажиллагчид аймгийн нийт албан бус сектор дах ажиллагчдын 68.7 хувийг эзэлж байна.

Хүснэгт 19: ҮНДСЭН АЖЛААРАА АЛБАН БУС СЕКТОРТ

АЖИЛЛАГЧДЫН ТОО, салбараар, 2015 оноор

	Үндсэн		Бүгд
	Хүйс		
	Эрэгтэй	Эмэгтэй	
Уул уурхай, олборлолт	98		98
Боловсруулах үйлдвэрлэл	311	208	519
Усан хангамж, бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент	54		54
Бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээ	450	1042	1492
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	281	48	329
Зочид буудал, байр сууц болон нийтийн хоолны үйлчилгээ		209	209
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	52		52
Боловсрол		49	49
Урлаг, үзвэр, тоглоом наадам	54	48	103
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	53	105	159
Бүгд	1354	1711	3065

Аймгийн хэмжээний албан бус сектор дах ажиллагчдын үндсэн ажлаараа хөдөлмөр эрхлэлтийн байдлыг салбараар нь авч үзэхэд бөөний болон жижиглэнгийн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээ эрхэлдэг хүмүүс хамгийн өндөр буюу 48.7 хувийг эзэлж байгаа бол эрэгтэйчүүдээс мөн 14.7хувийг, эмэгтэйчүүдийн хувьд 34.0 хувийг эзэлж байгаа нь хамгийн өндөр байна.

**Хүснэгт 20: ҮНДСЭН АЖЛААРАА АЛБАН БУС СЕКТОР ДАХ
АЖИЛЛАГЧДЫН ТОО, хүйс, ажил мэргэжлийн ангиллаар, 2015 оноор**

		Үндсэн		Бүгд
		Хүйс		
		Эрэгтэй	Эмэгтэй	
Үүнээс : ажил мэргэжлийн ангиллаар	Менежер	49		49
	Мэргэжилтэн	160	49	209
	Худалдаа, үйлчилгээний ажилтан	302	1401	1704
	Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажил	459	260	719
	Машин механизм, төхөөрөмжийн операторч, угсрагч	384		384
	Бүгд	1354	1711	3065

Хэнтий аймгийн хэмжээний үндсэн ажлаараа албан бус сектор дахь ажиллагчдын ажил мэргэжлийн ангилалыг нь авч үзэхэд худалдаа үйлчилгээний ажил мэргэжлийн ажил эрхэлдэг хүмүүс хамгийн өндөр буюу 55.6 хувийг эзэлж байгаа бол эрэгтэйчүүдээс мөн 15.0 хувийг үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажил эрхэлдэг, эмэгтэйчүүдийн хувьд худалдаа үйлчилгээний ажилтанууд 45.7 хувийг эзэлж байгаа нь хамгийн өндөр байна.

**Хүснэгт 21: ДАВХАР АЖЛААРАА АЛБАН БУС СЕКТОРТ АЖИЛЛАГЧДЫН ТОО,
хүйс, салбараар 2015 оноор**

		Давхар		Бүгд
		Хүйс		
		Эрэгтэй	Эмэгтэй	
Үүнээс : салбараар	ХАА, ойн аж ахуйн, загас барилт, ан агнуур	112		112
	Бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээ		56	56
	Зочид буудал, байр сууц болон нийтийн хоолны үйлчилгээ		59	59
	Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа		59	59
	Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын	106		106
	Урлаг, үзвэр, тоглоом наадам	48		48
Бүгд		266	173	439

Аймгийн хэмжээний албан бус сектор дахь ажиллагчдын давхар ажлаараа хөдөлмөр эрхлэлтийн байдлыг салбараар нь авч үзэхэд төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын ажил эрхэлдэг хүмүүс хамгийн өндөр буюу 24.1 хувийг эзэлж байгаа бол эрэгтэйчүүдээс 60.6 хувийг, эмэгтэйчүүдийн хувьд 39.4 хувийг эзэлж байгаа нь хамгийн өндөр үзүүлэлт байна.

**Хүснэгт 22: ДАВХАР АЖЛААРАА АЛБАН БУС СЕКТОРТ АЖИЛЛАГЧДЫН ТОО,
хүйс, ажил мэргэжлийн ангиллаар 2015 оноор**

		Давхар		Бүгд
		Хүйс		
		Эрэгтэй	Эмэгтэй	
Үүнээс :	Менежер	58	59	116
ажил	Мэргэжилтэн	48	59	107
мэргэжлийн	Худалдаа, үйлчилгээний ажилтан	48	56	104
ангиллаар	Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын мэргэшсэн ажилтан	112		112
Бүгд		266	173	439

Хэнтий аймгийн хэмжээний давхар ажлаараа албан бус сектор дахь ажиллагчдын ажил мэргэжлийн ангилалыг нь авч үзэхэд менежер мэргэжлийн ажил эрхэлдэг хүмүүс хамгийн өндөр буюу 26.4 хувийг эзэлж байгаа бол эрэгтэйчүүдээс мөн 25.5 хувийг Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын ажил, үйлчилгээний ажил эрхэлдэг, эмэгтэйчүүдийн хувьд менежер, мэргэжилтэнүүд тус тус 13.4 хувийг эзэлж байгаа нь хамгийн өндөр байна.

ДҮГНЭЛТ

Хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлтүүд нь хүн амын насны бүтэц, боловсролын байдлаас шууд хамаардаг бөгөөд хүн амын амьжиргааны түвшин, төрөлт, гэрлэлт, шилжих хөдөлгөөн зэрэг хүн ам зүйн үзүүлэлтүүдэд тодорхой нөлөө үзүүлдэг байна.

Эдийн засгийн идэвхитэй хүн амын 86.0 хувь нь ажиллагчид байна. Аймгийн ажиллагчдын тоо 2010 оноос хойших 5 жилд өссөн ба 2014 оны эцсийн дүнгээр өмнөх оноос 2.5 хувиар буурсан үзүүлэлттэй байсан бол 2015 оны эцсээр 15.2 хувиар өссөн байна.

Хөдөлмөрийн насны хүн амын тоо 2015 онд 45767 болж, өмнөх оноос 30 хүнээр буурсан байна. Үүнээс харахад манай аймагт эдийн засгийн идэвхитэй хүн амын болон ажиллагчдын тоо өмнөх оны тоон үзүүлэлтээс өссөн харагдаж байна. Энэ нь бүтээн байгуулалтын ажил их хийгдсэн нь ихээхэн нөлөөлсөн.

Ажиллах хүчний оролцооны түвшин 65.9 хувьтай байгаа нь улсын дунджаас 4.4 пунктээр их байна.

Аймгийн ажилгүйдлийн түвшин 2012-2013 онуудад өссөн бол 2015 оны жилийн эцсийн байдлаар авч үзвэл 14.0 хувьд хүрсэн нь өмнөх оны ажилгүйдлийн түвшингээс 3.7 пунктээр буурсан байна. Харин энэ нь улсын ажилгүйдлийн түвшингээс 6.5, Сүхбаатар аймгийн АТ-ээс 4.3, Дорнод аймгийн ажилгүйдлийн түвшингээс 6.1 пунктээр дээгүүр байна.

Ажиллагчдын тоо зүүн бүсийн хувьд 2007-2009 онуудад буурсан бол 2010-2012 онуудад өссөөр, 2013 онд 26.8 мянган хүн болсон байна. 2015 оны хувьд ажиллагчдын тоо 30.5 болж өмнөх оны ажиллагчдын тооноос 15.2 хувиар өсчээ. Аймгийн нийт ажиллагчид улсын хэмжээнд 2.6 хувийг, бүсийн хэмжээнд 35.3 хувийг эзэлж байна.

Аймгийн нийт ажиллагчдын 15.1 мян хүн буюу 49.5 хувийг эмэгтэйчүүд эзэлж байгаа ба улсын нийт эмэгтэй ажиллагчдын 2.8%, зүүн бүсийн 36.3 хувийг эзэлж байна. Харин Сүхбаатар аймгаас 2156 хүнээр, Дорнод аймгаас 1535 хүнээр тус тус их байна. Судалгааны үр дүнгээс харахад эмэгтэй ажиллагчид улс, бүсүүдийн хувьд эрэгтэй ажиллагчдаас доогуур хувьтай байгаа харагдаж байна.

Аймгийн нийт ажиллагчдыг боловсролын түвшнээр авч үзвэл хамгийн их хувийг техникийн болон мэргэжлийн боловсролтой иргэд 8816 буюу нийт ажиллагчдын 28.9%, дипломын болон бакалавр 7079 буюу 23.2%, бүрэн дунд боловсролтой 5394 буюу 17.7%-ийг тус тус эзэлж байгаа бол хамгийн бага хувийг боловсролгүй иргэд 1019 буюу 3.3 хувийг эзэлж байна. Магистр цолтой ажиллагчид нийт ажиллагчдын 0.4 хувь байна.

2015 оны байдлаар нийт ажиллагчдын хамгийн өндөр буюу 50.0 хувийг хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын салбарт ажиллагчид эзэлж байгаа бол бөөний болон жижиглэн худалдааны салбарт ажиллагчид 10.7 хувийг эзэлж байна.

Хэнтий аймгийн эдийн засгийн идэвхгүй хүн ам, улсын нийт эдийн засгийн идэвхгүй хүн амын 2.4 хувь, зүүн бүсийн 36.1 хувийг эзэлж байна.

Манай аймгийн хувьд эдийн засгийн идэвхгүй хүн амын тоо 2011 онд 26118, 2012 онд 17662, 2013 онд 15356, 2014 онд 18673 болж өссөн бол 2015 онд 18311 болж буурсан байна.

Зүүн бүс ажилгүй иргэдийн тоогоор 2015 онд улсын 5.3%-ийг эзэлж байгаа бол Хэнтий аймгийн ажилгүйчүүд зүүн бүсийн ажилгүйчүүдийн 47.9%-ийг эзэлж байна. Нийт ажилгүй иргэдийн эзлэх хувь Сүхбаатар аймгаас 23.7 пунктээр , Дорнод аймгаас 20.0 пунктээр тус тус их байна.

Эмэгтэй ажилгүй иргэдийн тоо улсын нийт ажилгүй эмэгтэйчүүдийн 4.8%, зүүн бүсийн нийт ажилгүй эмэгтэйчүүдийн 44.4 хувийг эзэлж байгаа бол Сүхбаатар аймгийн ажилгүй эмэгтэйчүүдээс 735 ажилгүй эмэгтэй хүнээр, Дорнод аймгаас 673 ажилгүй эмэгтэйчүүдээр их гэсэн тоо гарсан байна.

Хэнтий аймгийн ажилгүй иргэдийг боловсролын түвшингээр авч үзвэл хамгийн өндөр хувийг Дипломын дээд болон бакалаврын боловсролтой ажилгүй иргэд 24.9 %, техникийн болон мэргэжлийн боловсролтой ажилгүй иргэд 32.9% тус тус эзэлж байна.

Аймгийн нийт ажилгүй иргэдийн 28.0%-ийг 20-24 насны залуучууд, 25-29 насны ажилгүй иргэд 9.3 %, 30-34 насныхан 14.5 хувийг эзэлж байна. Хөдөлмөр эрхэлдэггүй эмэгтэйчүүдийн хувьд мөн 20-24, 30-34 насныхан өндөр хувийг эзэлж байна.

Улсын хэмжээнд нийт бүртгэлтэй ажилгүйчүүд өмнөх оноос 4182 хүнээр буурсан үзүүлэлтэй гарлаа. Зүүн бүсийн бүртгэлтэй ажилгүйчүүд улсын 7.3 хувийг эзэлж байгаа бол аймгийн нийт бүртгэлтэй ажилгүйчүүд зүүн бүсийн бүртгэлтэй ажилгүйчүүдийн 25.8 хувийг эзэлж байна.Сүхбаатар аймгаас 43.1 хувиар их, Дорнод аймгаас 45.9 пунктээр бага байна.

Аймгийн бүртгэлтэй ажилгүй эмэгтэйчүүдийн хувьд улсын 2.0%, бүсийн бүртгэлтэй ажилгүй эмэгтэйчүүдийн 27.2% -ийг эзэлж байна. Харин Сүхбаатар аймгийн бүртгэлтэй ажилгүй эмэгтэйчүүдээс 64.6 хувиар их, Дорнод аймгийн бүртгэлтэй ажилгүй эмэгтэйчүүдээс 48.4 хувиар бага байна.

Аймгийн хэмжээний албан бус сектор дах ажиллагчдын үндсэн болон давхар хөдөлмөр эрхлэлтийн байдлыг насаар нь авч үзэхэд 45-49 насныхан үндсэн ажлаараа албан бус хөдөлмөр эрхлэгчид хамгийн өндөр буюу 21.0 хувийг эзэлж байгаа бол эрэгтэйчүүдээс мөн 30-34 насныхан хамгийн өндөр 12.3 хувийг, эмэгтэйчүүдийн хувьд 35-39 насныхан 16.3 хувийг эзэлж байгаа нь хамгийн өндөр байна.

Хөдөөд албан бус сектор дах ажиллагчид аймгийн нийт албан бус сектор дах ажиллагчдын 66.5 хувийг эзэлж байна.

Ашигласан материал, номзүй:

1. www.1212.mn сайтаас хүн ам, хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдэл
2. Статистикийн улсын эмхтгэл- 2015
3. Ажиллах хүчний судалгааны үр дүн –2015
4. Аймгийн 2015 оны жилийн эцсийн нийгэм эдийн засгийн танилцуулга